



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/91

Улаанбаатар хот

Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2020 оны 152 дугаар тогтоол, 2025 оны 120 дүгээр тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаал, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 2 байршлын 2 нэгж талбарт газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдааг 2025 оны 06 дугаар сарын 11-ний өдөр цахим хэлбэрээр зохих журмын дагуу зохион байгуулсугай.

2. Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, зориулалт, хэмжээ анхны үнийг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдааг зохих журмын дагуу зохион байгуулахыг Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2025 он ажил\захирамж

1225010277



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 05 сарын 25-ны өдрийн 14 дүгээр
захирамжийн хавсралт

ЦАХИМ ХЭЛБЭРИЙН ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ
ГАЗРЫН БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ, ХЭМЖЭЭ, АНХНЫ ҮНЭ

№	Эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ (м2-аар)	Газрын анхны үнэ (төгрөг)	Дэнчингийн төлбөр 10% (төгрөг)
1.	БХД 1-р хороо, Үйлдвэрлэлийн бүсэд	Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	9992	4,796,160	479,616
2.	БХД 2-р хороо, Мэргэн	Төмс, хүнсний ногоо усалгаагүй тариалан	100873	1,754,686	175,468.6